

JSDF Санхүүжилтийн дугаар №TF0C2460

ЦАХИМ ХОРШОО ТӨСӨЛ

VIRTUAL COOPERATIVES OF PASTURAL LIVESTOCK COMMUNITIES PROJECT (VCPLCP) – P174733

ДЭД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

(Sub-grant Implementation Manual - SGIM)

ТОВЬЁОГ

ҮНДЭСЛЭЛ	4
АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ УДИРДАМЖ (ANTICORRUPTION GUIDELINES - ACG)	4
БҮЛЭГ 1. ЗОРИЛГО БА ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ	5
1.1. ЗОРИЛГО	5
1.2. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ	6
БҮЛЭГ 2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ	8
1.1 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРОО - ТУХ (PROJECT STEERING COMMITTEE - PSC)	8
1.2 ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ХОРОО – ТЗХ (PROJECT ADVISORY GROUP - PAG)	8
1.3 ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО - ТУХ (TECHNICAL APPRAISAL COMMITTEE - TAC)	8
1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ – ТХН (PROJECT MANAGEMENT UNIT - PMU)	10
1.5 ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА (FACILITATING AGENCY – FA)	10
БҮЛЭГ 3. ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР (ЭСЖТХ)-ИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ	12
3.1. ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ	12
3.2. АРГА ЗҮЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ	12
3.3. ДАМЖУУЛАН ТҮГЭЭХ ШАТАЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР (Cascade Training)	13
3.4. ДЭД ТӨСЛИЙН СТАНДАРТ БИЗНЕС ЗАГВАРЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ (Business Model)	13
3.5. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, СУРТАЛЧЛАХАД ЗОРИУЛСАН БАРИМТ БИЧИГ БЭЛТГЭХ	14
3.6. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
<i>Хүснэгт 1. Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үйл ажиллагааны зураглал</i>	17
<i>Хүснэгт 2. Ажил үүргийн урсгал дараалал: ТУХ, ТЗХ, ТУХ, ТХН, ХАБ</i>	18
БҮЛЭГ 4. ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР (ЭСЖТХ) ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	20
4.1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨМНӨХ ҮЕ ШАТ	20
4.1.1. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, СУРТАЛЧИЛАХ.....	20
4.1.2. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ.....	20
4.1.3. ЭСЖТХ-Т ХАМРАГДАХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛСЭН ӨРГӨДӨЛ ГАРГАХ.....	20
4.1.4. ӨРГӨДЛИЙГ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ БҮРТГЭХ	21
4.2. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ	22
4.2.1. УРТ ЖАГСААЛТААС (LONG LIST) ӨРГӨДӨЛ СОНГОЖ, БОГИНО ЖАГСААЛТ (SHORT LIST) ГАРГАХ	22
4.2.2. БОГИНО ЖАГСААЛТ БОЛОН НӨӨЦ ЖАГСААЛТАД БАГТСАН ХОРШООДЫГ ЧАДАВХЖУУЛАХ ...	23
4.2.3. ЦАХИМ ХОРШООНЫ ГИШҮҮДИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ	23
4.2.4. ДЭД ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХОРШООГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ.....	24
4.2.4.1. Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх.....	24

4.2.4.2.	Дэд төслийн санал болон хамтарсан санхүүжилт	24
4.2.4.3.	Дэд төслийн хүрээнд санхүүжүүлэх боломжгүй үйл ажиллагаанууд.....	25
4.2.5.	ДЭД ТӨСЛИЙН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ	25
4.2.6.	МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА БОЛОН ЭЦСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ.....	26
4.2.7.	ЭСЖТХ-ИЙН ЭЦСИЙН ШИЙДВЭР ГАРГАЖ БАТЛАХ.....	27
4.2.7.1.	Үнэлгээ хийх үйл явц.....	27
4.2.7.2.	Батлах үйл явц.....	27
4.2.7.3.	Мэдээлэх, санал хүсэлт хүлээн авах.....	27
4.2.8.	ДЭД ТӨСЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ.....	28
4.2.8.1.	Гэрээний бүтэц	28
4.2.8.2.	Гэрээ байгуулахаас өмнөх баталгаажуулалт	28
4.2.8.3.	Санхүүжилт болон үе шатаар санхүүжүүлэх хуваарь	29
4.2.8.4.	Гэрээ	29
4.2.9.	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ.....	29
4.2.9.1.	Хоршоодоор худалдан авах ажиллагаа явуулах.....	30
4.2.9.2.	Нэмэлт дэмжлэг	30
4.2.9.3.	Төсөл хэрэгжүүлэх нэгжээс худалдан авах ажиллагаанд хяналт тавих	31
4.2.10.	ДЭД ТӨСЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭСХҮЛ ЦУЦЛАХ	31
4.2.10.1.	Гэрээг цуцлах үндэслэлүүд	31
4.2.10.2.	Гэрээ цуцлагдсан тохиолдлын үр дагавар	32
4.2.11.	ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН (ЭСЖТХ) ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХААЛТ 32	
4.2.11.1.	Дэд төслийн хаалтын төлөвлөгөө	32
4.2.11.2.	Эд хөрөнгийн өмчлөл, шилжүүлэлт	33

Хүснэгт 3. Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг (ЭСЖТХ) хэрэгжүүлэх үйл явц.....34

ҮНДЭСЛЭЛ

Дэд төсөл хэрэгжүүлэх заавар нь JSDF Санхүүжилтийн дугаар №TF0C2460 тоот “Санхүүжилтийн гэрээ (*Letter Agreement*)” болон “Төслийн үйл ажиллагааны заавар (*Project operation manual - POM*)”-ын салшгүй хэсэг болно.

Дэд төсөл хэрэгжүүлэх зааврыг Дэлхийн банк болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) нь “Санхүүжилтийн гэрээ”-ний холбогдох заалтууд болох 1.02. заалтын (o), (p), (q), (r) заалтууд, 2.01. 2 дугаар хэсэг (a) заалт, 2.03. (b) (ii), (c) заалтууд болон 3.01. заалтын хүснэгтийн (5) дугаарт заасан; мөн “Төслийн үйл ажиллагааны заавар”-ын Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсгийн (a) хэсэгт заасны дагуу батална. Энэхүү баталгаа нь Эрэлтэд суурилсан жижиг төсөл хөтөлбөр - ЭСЖТХ (*Demand-Driven Small Grants Program - SGP*)-ийг хэрэгжүүлэх хүрээний нэг хэсэг юм.

АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ УДИРДАМЖ (*ANTICORRUPTION GUIDELINES - ACG*)

Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (ЭСЖТХ)-ийг хэрэгжүүлэхдээ “Санхүүжилтийн гэрээ”-ний 2.02 дугаар заалт, “Төслийн үйл ажиллагааны заавар”-ын VII бүлгийн F хэсэг болон XI бүлэгт заасан Авлигын эсрэг удирдамж, Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтуудыг чанд мөрдөнө. (4-р хавсралт: Луйвар ба авлигын эсрэг мэдээллийг үзнэ үү.)

БҮЛЭГ 1. ЗОРИЛГО БА ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. ЗОРИЛГО

Цахим хоршоо төслийн хүрээнд хэрэгжүүлж буй ЭСЖТХ-ийн зорилго нь анхдагч үйлдвэрлэгчид болон хоршоодын чадавхыг нэмэгдүүлэх, тэднийг Цахим хоршоо платформд элсүүлэн бүртгэж, платформыг идэвхтэй ашиглахыг дэмжих замаар замаар орлого нэмэгдүүлэх **Дэд төслүүд (sub-projects)**-ийг дэмжихэд оршино.

Тэтгэлэг авах эрх бүхий цахим хоршоод нь хуулийн этгээдийн хувьд хоршоодын холбоонд бүртгүүлсэн байх шаардлагатай. Холбоонд бүртгүүлэхийн тулд тэд хоршооны сайн засаглалыг бүрдүүлсэн байх ёстой. Эрх олгох шалгуурт цахим хоршоодыг ноос, ноолуурын үйлдвэрлэлд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээ болон/эсвэл дасан зохицох төлөвлөгөөний сургалтад хамрагдсан байхыг шаардана. Ингэснээр хоршоод үйл ажиллагаандаа уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх мэдлэг, үр чадвартай болох юм. Цахим хоршооны удирдагчид болон гишүүд хөрөнгө оруулалтыг хамтын оролцоотойгоор тодорхойлох, өргөдөл гаргах үйл явцын сургалтад хамрагдана.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар Японы Нийгмийн хөгжлийн сангийн (JSDF) дэмжлэгтэйгээр 2025-2026 онд хоёр жилийн хугацаатай Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг (ЭСЖТХ) хэрэгжүүлж байгаа бөгөөд дараах чиглэлүүдэд тэргүүлэх ач холбогдол өгнө:

- Дижитал платформоор дамжуулан олон нийтийг идэвхжүүлэх;
- Эмэгтэйчүүд, залуучууд болон эмзэг бүлгийн малчдыг дэмжих;
- Хоршоодын засаглал болон өртгийн сүлжээний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх.

Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (ЭСЖТХ)-ийг “Төслийн үйл ажиллагааны заавар”-т тодорхойлсон Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилт, Төслийн хөгжлийн зорилго (PDO) болон 1-р хавсралтад заасан Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд уялдуулан хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн амжилттай хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

	Бүрэлдэхүүн хэсгүүдээрх үйл ажиллагаа	Гарах үр дүн	Завсрын үр дүн	Төслийн хөгжлийн зорилтын үр дүн
С1: Цахим хоршоодыг идэвхжүүлэх	• Дижитал платформ хөгжүүлэлт • Малчдын хоршоодыг идэвхжүүлэх • Цахим академи	• Засаглалын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо тодорхойлогдож, бүрдсэн • Цахим хоршоод байгуулагдсан (25) • Цахим академиар дамжуулан малчид болон бусад платформын хэрэглэгчид сайн туршлагыг нэвтрүүлсэн	• Үйлдвэрлэлийн арга, технологи сайжирсан • Хоршоодын мэдлэг, үр чадвар нэмэгдсэн • Дижитал үйлчилгээний сүлжээ бий болсон	• Өрхийн орлого сайжирсан • Дижитал платформ бий болж, бодлого боловсруулалтад мэдээлэл, нотолгоо бий болсон

С2: Марчдыг зах зээлдэй холбох	- Цахим хоршоодод олгох жижиг бүцэлтгүй тусламж - Инновац нэвтрүүлэх - Нэмэлт үйлчилгээтэй холбох	- Хоршоод жижиг бүцэлтгүй тусламжаар дэмжигдсэн - Зах зээл болон үйлчилгээний харилцаа холбоо бэхжсэн - Санхүүгийн болон бусад үйлчилгээг платформоор дамжуулан хүртсэн	- Үйлдвэрлэл, бүтээмж нэмэгдсэн - Зах зээлд нэвтрэх боломж сайжирч орлого, үнийн урамшуулал хүртсэн	
С3: Төслийн удирдлага	- Хяналт шинжилгээ болон үнэлгээ - Мэдлэг түгээх	- Гүйцэтгэл хангалттай, чанарын сайжруулалт хийгдсэн - Оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний (M&E) тогтолцоо бүрдсэн - Нөлөөллийн болон харилцаа холбооны кампанит ажил хэрэгжсэн	- Төслийн хэрэгжилт үр ашигтай, үр дүнтэй болсон - Шилдэг туршлага, сургамжууд баримтжуулсан - Платформд тасралтгүй сайжруулалт хийсэн	

1.2. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Санхүүжилтийн гэрээний 2.01. Нэгдүгээр хэсгийн (c) (iv) дүгээрт заасны хүрээнд цахим хоршоодыг уламжлалт хоршоодын холбоонд бүртгүүлэхж, хоршооны сайн засаглалын зохицуулалтыг бүрдүүлэх ёстой. Үүнээс гадна, хоршоод нь Хоршооны тухай хуулийн дагуу байгуулагдсан, хууль ёсны бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг, тогтвортой байх шаардлагатай. Дээрх заалтыг Хоршооны тухай хуульд зааснаар анхан шатны хоршоо, дундын хоршоо, хоршоодын холбоо болон хоршооллын нэгдсэн холбоо хэлбэрээр хангаж болно.

“Санхүүжилтийн гэрээ”-ний 2.03 (c) (ii) (B) (2) (c) заалтын дагуу, дэд тэтгэлгийн хүрээнд эрх бүхий хүлээн авагч бүр нь энэхүү гэрээний нөхцөлийн дагуу дэд тэтгэлгээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг өөрөө зохион байгуулж, эдгээр бараа, ажил, үйлчилгээг зөвхөн дэд тэтгэлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон зорилгод хүрэхэд ашиглах үүрэгтэй.

Төслийн үйл ажиллагааны зааврын 26 (a) болон 85 дугаарт заасны хүрээнд сайн гүйцэтгэлтэй цахим хоршоод ноос, ноолуурын чанарыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор дэд төсөлд хамрагдах боломжтой. Хөрөнгө оруулалтад малчдад ноос, ноолуурын чанарыг сайжруулах жижиг тоног төхөөрөмж, тухайлбал цахилгаан хяргах төхөөрөмж эсвэл өндөр чанартай ноолуурын сам, одоо байгаа байр, агуулахыг засварлаж шинэчлэх, жижиг угаах машин, ноос, ноолуур ангилах, ялгах сав зэрэг багтаж болно.

Төслийн үйл ажиллагааны зааврын 26(a) заалтын дагуу, цахим хоршоод нь дижитал платформыг идэвхтэй ашиглаж, цахим болон талбайн сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцсон байх бөгөөд нийт гишүүдийнхээ дор хаяж 75 хувийг амжилттай хамруулсан байх шаардлагатай.

Дэлхийн банкнаас баталсан Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (*Environmental and Social Commitment Plan - ESCP*) болон Байгаль орчин, нийгмийн удирдлагын баримт бичиг (*Environmental and social management framework - ESMF*)-ийн хүрээнд ТХН болон хамтран ажиллах байгууллагаас боловсруулсан сургалтад хамрагдаж Дэд төслийн саналыг боловсруулна.

Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд санхүүжүүлсэн эрх бүхий ЭСЖТХ-ийн Дэд төслүүдийн тоо хамгийн багадаа 15 цахим хоршоо байх ба үүнээс 20% буюу хамгийн багадаа 3 цахим хоршоо нь эмэгтэй удирдагчтай байна. Мөн дээрх цахим хоршоод нь Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн бусад зорилтуудтай уялдаатайгаар хэрэгжүүлнэ. Энэхүү заалтын хүрээнд Төслийн зохицуулах хороо (ТЗХ) эсвэл Төслийн удирдах хороо (ТУХ)-оос ЭСЖТХ-ийг хүртээмжтэй байлгах зорилтын хүрээнд Цахим хоршоодоос ирүүлсэн Дэд төслүүдийн саналын [санхүүжилтийн дээд хэмжээг](#) тодорхойлно.

БҮЛЭГ 2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

1.1 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРОО- ТУХ (PROJECT STEERING COMMITTEE- PSC)

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын 10 дугаар зүйлд заасны дагуу, Төслийн удирдах хороо (ТУХ) нь Төслийн хэрэгжүүлэгч нэгжид (ТХН) бодлого болон үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж өгч, Санхүүжилтийн гэрээнд тусгагдсан төслийн зорилтыг тогтсон хугацаанд бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавих, төслийн болон үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг хянаж, батлах үүрэгтэй. Мөн ТУХ нь Дэд төсөл хэрэгжүүлэх гарын авлагыг батлах, ЭСЖТХ-ийн хэрэгжилтийг хангах, хоршоодын дэд төслүүдийг батлах, эцсийн шийдвэр гаргах үүрэгтэй.

1.2 ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ХОРОО – ТЗХ (PROJECT ADVISORY GROUP- PAG)

Төслийн зөвлөх хороо нь төслийн хэрэгжилтийн хугацаанд төслийг байнгын ажиллагаатай байлгах үүрэгтэйгээр Санхүүжилтийн гэрээний 1.02. (I), 2.03. (a) (i) болон Төслийн үйл ажиллагааны зааврын Нэгдүгээр бүлэг, Дөрөвдүгээр бүлгийн 33, 37, Наймдугаар бүлгийн 97 дугаарт тус тус заасны дагуу байгуулагдаж; Дэд төслийн хэрэгжилтэд бодлогын ерөнхий чиглэл, хяналт тавих, яамд хоорондын уялдаа холбоог хангах, Дэд төсөл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон тайланг батлах, эрх бүхий цахим хоршоодод дэд тэтгэлэг олгохыг баталгаажуулах үүрэгтэй. Төслийн зөвлөх хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

- i. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- ii. Төслийн удирдах хорооны гол гишүүд;
- iii. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төлөөлөгч;
- iv. Мал эмнэлгийн ерөнхий газрын төлөөлөгч;
- v. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн төлөөлөгч;
- vi. Хөдөө аж ахуйн их сургуулийн төлөөлөгч;
- vii. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны төлөөлөгч;
- viii. Мэргэжлийн холбооны шинжээч гишүүн;
- ix. Хувийн хэвшлийн шинжээч гишүүн.

1.3 ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО- ТУХ (TECHNICAL APPRAISAL COMMITTEE- TAC)

Техникийн үнэлгээний хороо нь Санхүүжилтийн гэрээний 1.02. (u), 2.03. (a) (ii) болон Төслийн үйл ажиллагааны зааврын Нэгдүгээр бүлэг, Гуравдугаар бүлгийн 26 (a) (c), Дөрөвдүгээр бүлгийн 33, 38, 39, Наймдугаар бүлгийн 97 дугаарт тус тус заасны дагуу техникийн болон санхүүгийн үнэлгээг хийх үүрэгтэй байгуулагдаж Дэд төслийн саналыг шударга, мэргэжлийн түвшинд, ил тод үнэлгээ хийж ажиллана.

Техникийн үнэлгээний хороо нь Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд ирүүлсэн дэд төслийн саналуудыг мэргэжлийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан үнэлж,

санхүүжилтийн шийдвэрийн талаарх санал дүгнэлтийг Төслийн зөвлөх хороонд/Төслийн удирдах хороонд (Тайлбар: эрх шилжүүлсэн тохиолдолд) танилцуулна.

Техникийн үнэлгээний хорооны гишүүд Дэд-төслийн саналыг үнэлэхдээ хүлээн зөвшөөрөх, хэлэлцэхээс татгалзах, эсвэл дахин засварлаж сайжруулах буюу хойшлуулах эрх, үүрэгтэйгээр оролцоно. ТҮХ-ийн гишүүд “Саналыг үнэлэх техникийн болон санхүүгийн шалгуур (*Technical and financial criteria for Evaluation of Proposal - TFCEP*)”-ын дагуу шалгуур бүрт оноо өгнө. Саналд өгсөн тайлбар, санал дүгнэлт, төслийн хэрэгжилтийг нарийвчлан авч үзэн, дэлгэрэнгүй тэмдэглэнэ.

ТҮХ-ийн хурлын нэгдсэн тэмдэглэл боловсруулж, бүх гишүүд гарын үсэг зурж, үнэлгээ зохих ёсоор хийгдсэнийг баталгаажуулна. ТҮХ-ны дарга энэхүү гарын үсэг зурсан хурлын тэмдэглэл мөн техникийн болон санхүүгийн үнэлгээний хавсралтуудыг Төслийн зөвлөх хороо/Төслийн удирдах хороонд танилцуулна.

Техникийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

Үнэлгээний хорооны дарга:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

Үнэлгээний хорооны гишүүд:

- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Салбарын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан шинжээч;
- Салбарын мэдээллийн технологийн бодлого, төлөвлөлт, шинжилгээ хариуцсан ахлах шинжээч;
- Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл хариуцсан шинжээч;
- Санхүү, хөрөнгө оруулалтын газрын төсөл хөтөлбөр, салбарын өр авлага хариуцсан ахлах мэргэжилтэн;

Нарийн бичиг:

- Цахим хоршоо төслийн шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх ажилтан.
- Техникийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар төслийн зохицуулагч ажиллана.

ТҮХ-ийн гол үүрэг:

- Бүх дэд төслийн саналыг шалгуур, техникийн шаардлагын дагуу хянах;
- Дэд төслийн саналуудыг урьдчилан тодорхойлсон аргачлалаар үнэлж, эрэмбэлэх;
- Санал болгож буй Дэд төслүүдийн богино жагсаалт болон эцсийн жагсаалтыг бэлтгэх;

- Гомдлын шийдвэрлэх үйл явц болон ашиг сонирхлын зөрчлийг хянах;
- Бүх хэлэлцүүлэг, шийдвэрийн үндэслэлийг тэмдэглэж, олон нийтэд ил тод байлгах зорилгоор баримтжуулах.

1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ – ТХН (PROJECT MANAGEMENT UNIT- PMU)

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын 10 дугаар зүйлд заасны дагуу болон Санхүүжилтийн гэрээний 1.02. (m), 2.03. (iii) дугаарт заасны дагуу байгуулагдаж Санхүүжилтийн гэрээ, Төслийн үйл ажиллагааны заавар болон энэхүү Дэд төсөл хэрэгжүүлэх зааварт заасны дагуу ЭСЖТХ-ийг хэрэгжүүлэн ажиллана.

Үнэлгээ, тайлагналын үйл ажиллагаа:

- Хоршооны хөгжил, ахиц дэвшлийг хянах, сөрөг нөлөөлөл болон эрсдэлийг мэдээлэх, хэрэгжилтийн асуудлыг шийдвэрлэх;
- Орон нутгийн түвшний үйл ажиллагааг үялдуулж, үр ашигтай хамтран ажиллах талуудтай хамтран тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ (M&E) хийх;
- Үйл ажиллагааны тайлан, завсрын тайлан, эцсийн тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд (ХХААХҮЯ) бэлтгэн хүргүүлэх.

1.5 ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА (FACILITATING AGENCY – FA)

Төслийн үйл ажиллагааны зааврын Дөрөвдүгээр бүлгийн 33, 40, 41 дүгээр зүйлд заасны дагуу, ТХН нь орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулах, малчид болон малчдын хоршоодод Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (ЭСЖТХ)-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн чадавхтай байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах боломжтой.

Хамтран ажиллах байгууллага нь Төслийн үйл ажиллагааны зааварт тодорхойлсны дагуу Төрийн бус байгууллага (ТББ), Иргэний нийгмийн байгууллага (ИНБ), их сургууль, мэргэжлийн холбоо эсвэл Мэргэжлийн нэгдсэн холбоо хэлбэртэй байж болно. Энэхүү байгууллага нь төслийн зорилгод нийцсэн сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах түршлагатай байх шаардлагатай.

Хамтран ажиллах байгууллагын ажил үүрэг

Хамруулах болон бүртгэлжүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Малчин өрхүүдийг тодорхойлох, дэмжих, хоршоонд бүртгүүлэх боломжтой санаачилгын бүлгүүдийг бүрдүүлэх;
- Малчид болон малчдын хоршоодыг Цахим хоршооны дижитал платформд бүртгүүлэх, нэгтгэх үйл явцыг хөнгөвчлөх;

- Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (ЭСЖТХ)-ийг хэрэгжүүлэхэд зохицуулалт, техникийн туслалцаа үзүүлэх;
- Малчдад зориулсан техникийн шийдэл, дижитал үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлэх.

Сургалт, зөвлөх үйлчилгээ болон чадавхжуулах үйл ажиллагааны /танхим болон цахимаар/:

- Орон нутгийн засаг захиргаа (*Local Government*), малчид, малчдын хоршоодод болон бусад оролцогч талуудад зориулсан чадавхжуулах хөтөлбөр, сургалт, туршлага солилцох ажлыг зохион байгуулна;
- Цахим хоршооны дижитал платформд бүртгэгдсэн санаачилгын бүлэг болон хоршоодод зориулан дэд төслийн санал боловсруулах, бизнес төлөвлөлт, хоршооны засаглалын чиглэлээр дамжуулан түгээх шаталсан сургалт (*cascade training*) зохион байгуулах;
- Дэд төслийн санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Байгаль орчин – нийгэм - засаглал (ESG)-ын чадавх бэхжүүлэх хөтөлбөр, сургалтыг боловсруулах, хэрэгжүүлэх.

БҮЛЭГ 3. ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР (ЭСЖТХ)-ИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

3.1. ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ

Эдгээр баримт бичиг нь Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (ЭСЖТХ)-ийн бүтэц, оролцогч талуудын үйл ажиллагааны эрх, үүрэг, удирдлага, зохион байгуулалтын зохицуулалт, мөн хоршоод болон бусад оролцогч талуудын хариуцлагыг тодорхойлно. Баримт бичгийг хуульч шинжээч хянаж, Дэлхийн банк баталснаар Монгол Улсын хууль, Японы Нийгмийн хөгжлийн сангийн бодлого, санхүүгийн тогтвортой байдлын стандартад бүрэн нийцсэн эсэхийг баталгаажуулна.

Дараах баримт бичгүүд багтана:

- Дэд төсөл хэрэгжүүлэх заавар;
- Орон нутгийн захиргаатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг;
- Чадавх бэхжүүлэх болон бүртгэлийн үйл ажиллагаанд Хамтран ажиллах байгууллагатай байгуулсан гэрээ;
- Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) байгуулах тухай шийдвэр;
- Дэд төслийн санхүүжилтийн гэрээний загвар.

3.2. АРГА ЗҮЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ

Төслийн хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь ЭСЖТХ-ийн хэрэгжилт, төслийн хөгжлийн зорилт, түүний шалгуур үзүүлэлтүүдийг хангах зорилгоор дэлгэрэнгүй арга зүйн удирдамжийг боловсруулна. Энэхүү баримт бичгийн багц нь төслийн хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдтэй үялдуулан, дэд төслийн бэлтгэл, хоршоодын чадавх бэхжүүлэх, хамгаалалтын шаардлагыг хангах гол асуудлуудыг стандартчилах бөгөөд байршил, боловсролын түвшин, түршлагаас үл хамааран бүх өргөдөл гаргагчдад тэгш боломжийг бүрдүүлнэ.

Арга зүйн удирдамж нь дараах агуулгыг хамарна:

- Газар нутгийн онцлогт тохирсон ноос ноолуур бэлтгэх дэд төсөл боловсруулах зааварчилгаа;
- Санхүүгийн загварчлал, эрсдэлийн үнэлгээ, тогтвортой байдлын загварууд;
- Хөрөнгө оруулалтын техникийн загварууд (жишээ нь: ноос хяргах, ноолуур самнах, угаах нэгж, агуулахын шинэчлэл, нарны хатаагч, сав баглаа боодлын төв гэх мэт);
- Дэд төслийн хүлээгдэж буй үр дүнгийн чанарын босго үзүүлэлтийг тодорхойлох арга зүй;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэл үнэлэх, бууруулах хялбаршуулсан энгийн анхан шатны үнэлгээний загвар.

Эдгээр арга зүйн удирдамжууд нь сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж болохуйц цахим болон хэвлэмэл хэлбэрээр түгээгдэнэ. Энэ нь зөвхөн өргөдөл гаргагчдыг чанартай санал боловсруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна, Хамтран ажиллах байгууллага, Техникийн үнэлгээний хорооны гишүүдэд бүх өргөдлийг нэг ижил техникийн стандартын дагуу үнэлэх боломжийг бүрдүүлнэ.

3.3. ДАМЖУУЛАН ТҮГЭЭХ ШАТАЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР (Cascade Training)

Өргөдөл гаргагчдыг чадавхжуулах, техникийн түслалцааг жигд, стандартчилагдсан хэлбэрээр хүргэхийн тулд ЭСЖТХ-г хэрэгжүүлэхээс өмнө шаталсан бүтэцтэй сургалтын хөтөлбөрийг зохион байгуулна.

Сургалт нь хоёр түвшинд хэрэгжинэ.

- I түвшин – Сургагч багш нар: Хөтөлбөрийн зорилго, шалгуур, тэтгэлэг бэлтгэх, хоршооны хөгжил, худалдан авалт, санхүүгийн баримт бичиг, хамгаалалтын шаардлага зэрэг бүх агуулгаар мэргэшсэн зөвлөх, ТХН-ийн техникийн ажилтан, сургагч багш нарын ахлагч нар сургалтад хамрагдана;
- II түвшин – Хамтран ажиллах байгууллага: Эдгээр сургагч багш нар нь дараа нь бүс нутгийн онцлогт тохируулсан сургалтыг сумын түвшний сургагч, өргөтгөлийн ажилтан, хоршооны төлөөлөгчдөд зохион байгуулна.

Шаталсан сургалтад дараах арга хэрэгслийг ашиглана:

- Стандарчлагдсан модулиуд болон гарын авлага;
- Жишээ тохиолдол болон стандарт дэд төслийн алхамчилсан тайлбар;
- Өргөдөл бэлтгэх, үнэлэх үйл явц;
- Оролцогчдын ойлголт, бэлэн байдлыг баталгаажуулах үнэлгээний хэрэгсэл.

Энэхүү хоёр түвшний тогтолцоо нь ЭСЖТХ-ийн хэрэгжилтийн бүх үе шатанд өргөн хүрээг хамрах, техникийн чанарын тогтвортой байдлыг хангана.

3.4. ДЭД ТӨСЛИЙН СТАНДАРТ БИЗНЕС ЗАГВАРЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ (Business Model)

Дэд төслийн санал боловсруулах үйл явцыг хялбарчилж, техникийн хувьд найдвартай, эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд ТХН нь стандарт бизнес загварчлал (СБЗ) боловсруулна. СБЗ нь өргөдөл гаргагч хоршоодын орон нутгийн нөхцөлд тохируулан ашиглах боломжтой дэд төслийн загварчлал байх болно. СБЗ-ийг ашигласнаар бизнес төлөвлөлт, техникийн бичиг баримтын түршлага багатай шинэ хоршоод хөтөлбөрт тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг олгох зорилготой юм.

СБЗ нь техникийн үнэлгээг хялбарчилж, хөрөнгө оруулалтын санал хэт их эсвэл дутуу төлөвлөгдөх эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

СБЗ-ийн хамрах хүрээ:

- Зорилго, үндсэн үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийн алхмуудыг тусгасан суурь бизнес төлөвлөгөөний загвар;
- Анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, шаардлагатай тоног төхөөрөмж, ажиллах хүч, үйл ажиллагааны зардал зэргийг урьдчилан тодорхойлсон үзүүлэлтүүд;
- Зах зээлийн мэдээлэлд үндэслэсэн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын төсөөлөл бүхий төсвийн загвар;
- Санхүүжилтийн үе шаттай олголт бүхий хуваарь;
- Эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хамгаалалтын үзүүлэлтүүд (Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах үзүүлэлтүүд);
- Санхүү, эдийн засгийн үр нөлөөг хянах үзүүлэлтүүд.

Эдгээр стандартчилагдсан загварчлалууд нь ноос ноолуурын салбарт дараах орлого нэмэгдүүлэх боломжуудыг хамруулна:

- Ноос ноолуур бэлтгэх төхөөрөмж;
- Ноос ноолуур угаах, цэвэрлэх төхөөрөмж, жижиг хэмжээний угаах эсвэл боловсруулах шугамууд (байгаль орчны нөлөөллийг анхаарах);
- Ангилж ялгах тоног, төхөөрөмж, хэрэгсэл;
- Хадгалалт, тээвэрлэлтэд зориулсан сав баглаа боодлын шийдлүүд;
- Малыг шүршиж угаах төхөөрөмж (байгаль орчны нөлөөллийг анхаарах);
- Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг, эсвэл эрчим хүчнээс хамааралгүй ашиглагдах багаж хэрэгслүүд (ноос шахагч, пресслэгч гэх мэт);
- Цахим худалдаа, цахим платформын шийдлийг ашиглах загвар зэрэг байж болно.

3.5. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, СУРТАЛЧЛАХАД ЗОРИУЛСАН БАРИМТ БИЧИГ БЭЛТГЭХ

ЭСЖТХ-ийн зорилго, эрх олгох шалгуур, өргөдөл гаргах журам, дэмжлэгийн механизмын талаар — ялангуяа алслагдсан болон үйлчилгээ дутмаг бүсийн өргөдөл гаргагчид — бүрэн мэдээлэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүртээмжтэй, олон нийтэд чиглэсэн мэдээллийн аяныг зохион байгуулна.

ТХН олон нийтэд чиглэсэн мэдээллийн багц бэлтгэн түгээнэ. Үүнд:

- ЭСЖТХ-ийн талаар тайлбарласан постер, танилцуулга, гарын авлага (хэвлэмэл болон цахим хэлбэрээр);
- Радио, телевиз, цахим сүлжээнд ашиглах материал;

- Хоршоодод зориулсан өргөдөл бэлтгэх алхамчилсан заавар, түгээмэл асуулт, хариултын жагсаалт;
- Хамрагдах боломжтой дэд төслийн мэдээлэл, хамтран санхүүжилтийн шаардлагыг тайлбарласан инфографикууд.

Мэдээллийн агуулгад дараах зүйлс багтана:

- ЭСЖТХ-д хэн оролцох боломжтой, дэд төслийн саналыг хэрхэн гаргах, ямар үйл ажиллагаа санхүүжилт авах боломжтой талаар тодорхой тайлбар;
- Төсөлд хамрагдахын тулд Хоршооны тухай хуульд зааснаар анхан шатны хоршоо, дундын хоршоо, хоршоодын холбоо болон хоршооллын нэгдсэн холбоо байх тухай;
- Төслийн хүрээнд урьдчилсан зөвлөгөө авахыг уриалах;
- Холбоо барих хаяг, мэдээлэл (утас, имэйл, вэбсайт, дижитал платформ)-ийг хүргэх.
- Төсөл хэрэгжүүлэх хугацаа, ажлыг тодорхой хуваарь, сонирхлоо илэрхийлэх болон өргөдөл хүлээн авах хугацааны товыг олон нийтэд зарлан мэдээлнэ.

Эдгээр материалыг ЭСЖТХ-ийн цахим платформд байршуулна. Цахим платформ нь дараах шаардлагыг хангасан байна:

- Өргөдлийн маягт, зааварчилгааны материалыг татаж авах боломжтой байх;
- Бүс нутгаар нь ангилсан хөтөлбөрийн гол холбогдох ажилтнууд, хамтран ажиллах байгууллага, оролцогч талуудын мэдээлэл;
- Дэд төслийн өргөдөл хүлээн авах хугацаа, сургалтын үйл ажиллагаа, сонгон шалгаруулалтын мэдээллийг байршуулж, тогтмол шинэчлэх;
- Санал хүсэлт хүлээн авах, гомдол шийдвэрлэх механизмыг ажиллуулах боломжтой байх.

ТХН нь уг вэб сайтыг Монгол болон Англи хэл дээр тогтмол шинэчилж, ил тод, хүртээмжтэй байдлыг хангах үүрэгтэй.

3.6. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны аяныг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд, ТХН нь орон нутгийн засаг захиргаа болон хамтран ажиллагч байгууллагуудтай хамтран зорилтот сумдад хурал уулзалт хийн мэдээлэл түгээх төлөвлөгөөг боловсруулна. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд:

- Малчид, малчдын хоршоо, эмэгтэй тэргүүлэгчтэй хоршоо, эмзэг бүлгийн өрх болон бусад оролцогч талуудад ЭСЖТХ-ийн зорилго, журам, үйл явцыг танилцуулах;
- Хоршоо байгуулах эсвэл хоршоонд нэгдэхийн ач холбогдол, хариуцлагыг тайлбарлах;
- Стандарт Бизнес Загварчлалууд (СБЗ), дэд төслийн шаардлага, өргөдөл гаргах үйл явцыг танилцуулах;

- Цахим хоршоо платформд бүртгүүлэх, өргөдлийн маягт бөглөх, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх талаар сургалт зохион байгуулах зэрэг багтана.

Төлөвлөгөөг орон нутгийн нөхцөлд нийцүүлж, хүртээмжтэй, хамрах хүрээ өргөн байх үүднээс:

- Эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийн өрхүүдийг идэвхтэй хамруулах тусгайлсан арга хэмжээ авах;
- Бичиг үсгийн болон дижитал хэрэглээний боломж хязгаарлагдмал иргэдэд зориулсан нөхцөлийг бүрдүүлэх.

Хүснэгт 1. Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үйл ажиллагааны зураглал



Хүснэгт 2. Ажил үүргийн үрсгал дараалал: ТҮХ, ТЗХ, ТҮХ, ТХН, ХАБ

Үйл ажиллагааны нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Оролцогч талууд	Баримт бичиг / Аргачлал / Мэдээллийн эх сурвалц	Хэрэгжилтэд хариуцах этгээд
Мэдээлэл түгээх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх ажил болон сургалтууд	7 өдөр	Зорилтот байршлын малчид, малчин өрхүүд, малчдын хоршоод	ДТХЗ-ийн сргон шалгаруулалтын өмнөх үе шатны 4.1.1 болон 4.1.2-р хэсэгт заасан үйл ажиллагааг Баримт бичиг боловсруулах болон батлах үе шатны 3.6 болон 3.7-р хэсэгт заасан баримт бичгүүдийн дагуу хэрэгжүүлнэ.	Орон нутгийн засаг захиргаа, Хамтран ажиллах байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгж
Өргөдөл бөглөх болон илгээх үйл ажиллагаа	7 өдөр	Малчид, бүх түвшний хоршоод, шинэ хоршоо байгуулах хүсэлтэй иргэд, Дэд төсөлд хамрагдах хүсэлтэй оролцогчид	Хавсралтын дагуу малчид, хоршоод Цахим хоршооны платформд бүртгүүлж, өргөдлөө бөглөн ирүүлнэ. ДТХЗ-ийн 4.1.3 дугаар үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Орон нутгийн засаг захиргаа, Хамтран ажиллах байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгж
Өргөдлийг ТХН-ийн бүртгэлд авах	Өргөдөл хүлээн авах эцсийн хугацааг үндэслэн бүртгэл хөтөлнө	ТХН	ТХН нь ирүүлсэн бүх өргөдлийг албан ёсоор бүртгэн, төвлөрсөн мэдээллийн санд хөтөлж, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийх боломжийг бүрдүүлнэ. ДТХЗ-ийн 4.1.4 дүгээр үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	ТХН нь шалгуур хангасан өргөдлүүдийг боловсруулж, ТҮХ-д шилжүүлнэ
Урт жагсаалтаас өргөдөл сонгон шалгаруулж, богино жагсаалт бэлтгэх	7 өдөр	ТҮХ	ДТХЗ-ийн 4.2.1 дүгээр хэсгийн дагуу өргөдлүүдийг Урт жагсаалтаас сонгон авч, Богино жагсаалтыг бэлтгэнэ.	ТҮН (ТХН-ний дэмжлэгтэйгээр)
Богино жагсаалтад багтсан өргөдөл гаргагчдад чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах	14 өдөр	Богино жагсаалтад багтсан бүх хоршоодын төлөөлөл; санаачлагч бүлэг бүрээс дор хаяж нэг үндсэн гишүүний оролцоо заавал байна	ДТХЗ-ийн 4.2.2 болон 4.2.3 дугаар хэсгүүдийн дагуу сургалт болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна	Орон нутгийн засаг захиргаа, Хамтран ажиллах байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгж
Хоршоодыг улсын бүртгэлд бүртгүүлэх	45 өдөр	Шинэ хоршоо байгуулах, одоо байгаа хоршоог шинэчлэх, эсвэл нэгдэн хоршоо байгуулах, холбоонд элсэх хүсэлтэй малчид болон хоршоод	ДТХЗ-ийн 4.2.2 болон 4.2.3 дугаар хэсгүүдийн дагуу шинэ хоршоо байгуулах болон одоо байгаа хоршоог дахин зохион байгуулах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнтэй зэрэгцэн дэд төслийн санал хүлээн авч, хоршоодыг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хоршоод холбоонд элсэнэ.	Орон нутгийн засаг захиргааны дэмжлэгтэйгээр ТХН
Эрэлтэд суурилсан жижиг төсөл хөтөлбөрийн дэд төслийн санал хүлээн авах		Хоршоод	ДТХЗ-ийн 4.2.4 дүгээр хэсгийн дагуу бүрэн боловсруулсан дэд төслийн саналуудыг хүлээн авна	Хамтран ажиллах байгууллагын дэмжлэгтэйгээр ТХН
Дэд төслийн баримт бичгийг хүлээн авч бүртгэх, санал ирүүлэх эцсийн хугацааг мөрдөх, эцсийн жагсаалт бэлтгэх	7 өдөр	Хоршоод	ДТХЗ-ийн 4.2.5 болон 4.2.6 дугаар хэсгүүдийн дагуу хоршоодоос ирүүлсэн дэд төслийн саналуудыг хүлээн авч бүртгэнэ. Бүртгэл	ТХН-ний дэмжлэгтэйгээр ТҮХ

			хаагдсаны дараа Эцсийн жагсаалтыг бэлтгэнэ. ТҮХ нь хүлээн авсан бүх дэд төслийн саналыг иж бүрэн үнэлгээний матриц ашиглан үнэлнэ.	
Дэд төсөл хөтөлбөрийн хүрээнд эцсийн шийдвэр гаргах болон батлах	7 өдөр	Төслийн зөвлөх хорооны хурал	ДТХЗ-ийн 4.2.7 дугаар хэсгийн дагуу ТЗБ хуралдаж, Дэд төсөл хөтөлбөрийн хүрээнд эцсийн шийдвэр гарган батална	ТХН-ийн дэмжлэгтэйгээр ТЗХ/ТУХ
Дэд төслийн гэрээ байгуулах	7 өдөр	ТХН, ХХААХҮЯ, сонгогдсон хоршоод	ДТХЗ-ийн 4.2.8 дугаар хэсгийн дагуу ТЗХ-оор дэд төсөл батлагдсаны дараа ХХААХҮЯ нь хоршоодтой дэд төслийн гэрээ байгуулна	ТХН-ны дэмжлэгтэйгээр ХХААХҮЯ
Дэд төсөл хөтөлбөрийн хүрээнд худалдан авалт хийх	Дэд төслийн гэрээний дагуу	Сонгон шалгаруулалтаар тодорхойлогдсон байгууллага	ДТХЗ-ийн 4.2.9 дүгээр хэсгийн дагуу бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг санхүүжүүлж, хэрэгжүүлнэ	Хоршоод

БҮЛЭГ 4. ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР (ЭСЖТХ) ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэ хэсэгт хөтөлбөрийг албан ёсоор эхлүүлж хэрэгжүүлэх үйл ажиллагааны дарааллыг тодорхойлсон болно. Энэхүү үе шат нь Дэд төслийн өргөдөл гаргах, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах бүх үйл явцыг ил тод, үр ашигтай, хүртээмжтэй байлгах зорилготой.

4.1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨМНӨХ ҮЕ ШАТ

4.1.1. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, СУРТАЛЧИЛАХ

Сурталчилгааны материал болон цахим платформыг бэлтгэсний дараа, Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг олон нийтэд албан ёсоор танилцуулах, мэдээлэх аяныг эхлүүлнэ. Энэхүү аяныг Хамтран ажиллах байгууллага болон Төсөл хэрэгжүүлэх нэгж нь орон нутгийн засаг захиргаатай хамтран удирдан зохион байгуулна.

Мэдээлэл, сурталчилгааны аяны сувгууд дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Телевиз, радио, сошиал медиа сувгууд болон албан ёсны вэбсайт;
- Алслагдсан бүс нутгуудад зохион байгуулах биечилсэн олон нийтийн уулзалтууд болон үүрэн холбоо ашиглан танилцуулах;
- Сумын Засаг даргын тамгын газар, зах, хоршооны төвүүдэд байрлуулах сурталчилгааны баннер, постерууд;
- Малчдын хоршоо, холбоо, эмэгтэйчүүдийн бүлэг, ТББ-аар дамжуулан зар мэдээ, уриалга тараах гэх мэт

4.1.2. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах сурталчилгаатай зэрэгцэн, хөтөлбөрт хамрагдах аймаг, сум бүрт биечлэн мэдээлэл өгөх сургалт, уулзалтуудыг зохион байгуулна. Эдгээр сургалт, уулзалтууд нь малчид болон хөдөөгийн бусад оролцогч талуудад хөтөлбөрийн талаарх ойлголт авах боломжийг олгоно.

Уулзалтын хүрээнд:

- Хамтран ажиллах байгууллага, Төсөл хэрэгжүүлэх нэгж болон орон нутгийн засаг захиргааны байгууллага зохион байгуулна;
- Өргөдөл гаргах үйл явцыг жишээгээр тайлбарлан, зааварчилгаа өгнө;
- Түгээмэл асуулт, санал хүсэлтэд хариулт өгч, хэлэлцүүлэг явуулна;
- Стандарт бизнес загварчлалын загвар маягтууд болон хэрэглэгчийн гарын авлагын хэвлэмэл хувилбарыг оролцогчдод тараана.

4.1.3. ЭСЖТХ-Т ХАМРАГДАХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛСЭН ӨРГӨДӨЛ ГАРГАХ

Мэдээлэл, сурталчилгаа болон сургалт, уулзалтуудаар дамжуулан мэдээлэл авсны дараа сонирхсон малчид, малчдын хоршоод, Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрт

(ЭСЖТХ) хамрагдах анхан шатны өргөдлийг бэлтгэн илгээнэ. Өргөдлийг цахим хоршооны платформоор дамжуулан хүлээн авах бөгөөд малчид, анхан шатны хоршоо, дундын хоршоо, хоршоодын холбоо болон хоршооллын нэгдсэн холбоо платформд заавал бүртгүүлсэн байна.

Өргөдөл гаргагчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хоршооны тухай хууль тогтоомжийг мөрдөх (доод тал нь 9 гишүүнтэй байх);
- Хоршоо албан ёсоор бүртгэгдээгүй тохиолдолд хоршоо байгуулах, бүртгүүлэх хүсэл, зорилгоо илэрхийлэх;
- Нэг хоршооноос зөвхөн нэг дэд төслийн санал гаргах.

Стандарт бизнесийн загварт багтсан заавар, маягтуудыг ашиглан, шаардлагатай тохиолдолд ТХН болон хамтран ажиллах байгууллагын дэмжлэгтэйгээр малчид, хоршоод дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Анхан шатны өргөдлийн маягтыг бүрэн бөглөх;
- Дэд төслийн санал, зорилго болон хүлээгдэж буй үр дүнг тодорхойлон тайлбарлах;
- Хамтран санхүүжүүлэх бэлэн байдал болон хоршоо байгуулах амлалт, үүргээ илэрхийлэх.

Өргөдлийг хүлээн авсан тухай баталгаажуулсан мэдэгдлийг өргөдөл гаргагч бүрт хүргүүлнэ.

4.1.4. ӨРГӨДЛИЙГ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ БҮРТГЭХ

Өргөдлүүдийг хүлээн авсны дараа Төсөл хэрэгжүүлэх нэгж (PMU) нь ирүүлсэн өргөдөл бүрийг албан ёсоор бүртгэж, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийх зорилгоор нэгдсэн мэдээллийн санд оруулна. Өргөдөл бүрт давтагдашгүй код олгож, дараах үзүүлэлтүүдээр ангилна. Үүнд:

- Аймаг, сум, баг;
- Салбар – чиглэл (жишээ нь, ноос хяргах, ширхэгт ялгах гэх мэт);
- Санал болгож буй хөрөнгө эмжээ болон төсөвт өртөг;
- Хүйс, нас болон эмзэг байдлын шалгуур үзүүлэлтүүд.

ТХН нь бүх өргөдөл анхан шатны шаардлага, шалгуурыг бүрэн хангасан эсэхийг нягталж шалгана. Дутуу бөглөгдсөн эсхүл тодорхой шалгуур хангаагүй өргөдлүүдийг тэмдэглэн, холбогдох санал, тайлбарын хамт өргөдөл гаргагчид буцаана. Харин шаардлага хангасан өргөдлүүдийг Техникийн үнэлгээний хороонд хянан хэлэлцүүлэхээр шилжүүлнэ.

Ил тод байдлыг хангах үүднээс бүртгэгдсэн өргөдлийн товч жагсаалтыг нэрийн нууцлалтайгаар үйл ажиллагааны төрөл болон байршлын мэдээллийг нийтэд нийтэлнэ.

4.2. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

4.2.1. УРТ ЖАГСААЛТААС (LONG LIST) ӨРГӨДӨЛ СОНГОЖ, БОГИНО ЖАГСААЛТ (SHORT LIST) ГАРГАХ

Бүртгэлийн үе шат дууссаны дараа Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) нь шаардлага хангасан бүх анхан шатны өргөдлийн бүрдэл, иж бүрдэл, нийцлийг хянан шалгаж, шалгуурт нийцсэн өргөдлүүдийг тодорхойлон “Хоршооны дэд төслийн санал боловсруулах үе шат”-д шилжүүлнэ.

Анхан шатны өргөдлүүдийг бүртгэж, урт жагсаалт (Long List) бүрдүүлэх ажлыг Цахим хоршооны платформоор дамжуулан гүйцэтгэнэ. Өргөдөл хүлээн авах болон цахим платформд бүртгэх үйл ажиллагааг Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь Хамтран ажиллах байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Цахим платформд бүртгэгдэх Анхан шатны өргөдлийн маягтыг Дэлхийн банк хянан үзэж, баталгаажуулсан болно.

Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) нь цахим платформд бүртгэгдсэн, урт жагсаалтад багтсан өргөдлүүдийг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу иж бүрдэл, нийцлийн хувьд хянан үнэлнэ. Үүнд:

- Анхан шатны өргөдлийн бүрдэл болон сонирхол илэрхийлсэн байдал нь тодорхой, ойлгомжтой эсэх;
- Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн зорилготой нийцэж байгаа эсэх;
- Санал болгож буй дэд төслийн техникийн хэрэгжих боломж, бодит байдал болон ач холбогдол;
- Хоршоо байгуулах бэлэн байдал, идэвх санаачилга, эсхүл хоршоо аль хэдийн байгуулагдсан эсэх;
- Бизнес болон үйл ажиллагааны суурь ойлголттой эсэх;
- Өргөдөл гаргагчдын газарзүйн байршил, хүйс, нийгэм-эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж байгаа эсэх.

Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) анхан шатны өргөдлийг онооны системээр хянаж, дараах байдлаар үнэлнэ:

- Өндөр оноо авсан санаачлагч бүлгүүдийн богино жагсаалт (Short List)-ыг бүрдүүлнэ;
- Богино жагсаалтад багтсан аливаа бүлэг татгалзах, эсхүл сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж чадаагүй тохиолдолд ашиглах нөөц жагсаалт (Reserve List)-ыг мөн бэлтгэнэ.

Батлагдсан богино жагсаалт болон нөөц жагсаалтыг Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь цахим хоршооны платформ болон аймаг, сумын түвшний мэдээллийн самбаруудад олон нийтэд нээлттэйгээр нийтэлнэ.

4.2.2. БОГИНО ЖАГСААЛТ БОЛОН НӨӨЦ ЖАГСААЛТАД БАГТСАН ХОРШООДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

Богино жагсаалтад багтсан малчид болон хоршоодыг дараагийн үе шатанд бэлтгэх зорилгоор Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) болон Хамтран хэрэгжүүлэгч байгууллага (FA)-аас чиглэсэн техникийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ. Энэхүү дэмжлэгт дараах үйл ажиллагаанууд хамаарна. Үүнд:

- Хоршоод холбоонд нэгдэх эсвэл нэгдэн холбоо байгуулах, засаглалын бүтэц болон эрх зүйн шаардлагыг хангахтай холбоотой зөвлөмж, дэмжлэг үзүүлэх;
- Албан ёсны дэд төслийн саналыг (Sub-Project Proposal) боловсруулахад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Хамтран санхүүжилт бүрдүүлэх, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт боловсруулах талаар заавар, чиглэл өгөх.

4.2.3. ЦАХИМ ХОРШООНЫ ГИШҮҮДИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ

Хоршоодын чадавхыг бэхжүүлэх, хэрэгжилтийн үе шатанд бэлэн байдлыг хангах зорилгоор богино жагсаалтад багтсан бүх малчдын хоршоодод Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн хяналт дор мэргэжилтэн, сургагч багш нар сургалт зохион байгуулна.

Сургалт нь дараах агуулгаас бүрдэнэ. Үүнд:

- Хоршоо байгуулах, засаглалын бүтэц зохион байгуулалт;
- Бизнес төлөвлөлт, үйл ажиллагааны менежмент;
- Санхүүгийн бүртгэл хөтлөлт, хамтран санхүүжилтийн шаардлага;
- Худалдан авах ажиллагааны үүрэг хариуцлага болон орон нутгийн зах зээлтэй хамтран ажиллах;
- Байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагууд;
- Хяналт шинжилгээ, гүйцэтгэлийн тайлагнал, ЭСЖТХ-ийн нөхцөл шаардлагын хэрэгжилт.

Сургалтад хоршоо бүрээс дор хаяж нэг үндсэн гишүүн заавал хамрагдана. Сургалтад бүрэн хамрагдсан оролцогчдод сургалт дүүргэсэн гэрчилгээ олгож, уг гэрчилгээг эцсийн өргөдлийн багцад хавсаргана.

Эдгээр чадавх бэлхжүүлэх үйл ажиллагаа нь ЭСЖТХ-ийн дараагийн шатанд чадавхжсан хоршоодыг шалгаруулахад чухал шүүлтүүр болно.

4.2.4. ДЭД ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХОРШООГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ

Богино жагсаалтад багтсан хоршоод ЭСЖТХ-ийн хүрээнд дэд төслийн саналыг боловсруулна. Улсын бүртгэлд бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлдэг хоршоод нь шууд Дэд-төслийн санал бэлтгэх боломжтой бөгөөд шинээр анхан шатны хоршоо байгуулах мөн дундын хоршоо болон хоршоодын холбоо нэгдсэн хоршоо хуулийн дагуу байгуулж Дэд төслийн санал бэлтгэн ЭСЖТХ-т хамрагдах боломжтой.

4.2.4.1. *Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх*

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын дэмжлэгтэйгээр хоршоод дараах баримт бичиг, үйл ажиллагааг бүрдүүлж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хоршооны дүрмийг боловсруулах, батлуулах үйл явц;
- Хоршооны удирдах зөвлөлийг сонгон байгуулах;
- Хоршооны нэр дээр банкны данс нээх;
- Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан ёсоор бүртгүүлэх.

Зөвхөн хууль ёсоор улсын бүртгэлд бүртгэгдсэн хоршоод нь албан ёсны дэд төслийн саналыг боловсруулж, Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр (SGP)-ийн хүрээнд сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй байна.

4.2.4.2. *Дэд төслийн санал болон хамтарсан санхүүжилт*

Дэд төслийн санхүүжилтэд хамрагдахаар хоршоодоос боловсруулж ирүүлэх төслийн санал дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Стандарт бизнес загварт (Standard Business Model) суурилсан дэлгэрэнгүй бизнес төлөвлөгөө;
- Хамтран санхүүжилтийн оролцоог баримтжуулсан санхүүжилтийн төлөвлөгөө;
- Тоног төхөөрөмж, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөө;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны үнэлгээ, менежментийн төлөвлөгөө (шаардлагатай бол);
- Санхүүжилтийг олгох үе шаттай уялдсан санхүүгийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан хэрэгжилтийн хуваарь;
- Хоршооны гишүүдийн үүрэг, хариуцлагын хуваарилалт.

Дэд төсөл хөтөлбөрийн санхүүжилт нь нийт төслийн хүрээнд нийт 15-аас дээш тооны хоршоог дэмжих бөгөөд нэг дэд төслийн санхүүжилтийн дээд хэмжээ нь 50,000 (тавин мянган) ам.доллар, буюу ойролцоогоор 180,000,000 (нэг зуун наян сая) төгрөг байна. Албан ёсны төслийн саналыг боловсруулахад сургагч багш, мэргэжилтэн, зөвлөхүүд дэмжлэг

үзүүлж болох бөгөөд саналын агуулга нь заавал тухайн хоршооны эзэмшил, алсын хараа, санаачилгыг бүрэн илэрхийлсэн байна.

Бүрэн боловсруулсан өргөдлийн багцыг Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн (ЭСЖТХ) эцсийн үе шатнаас өмнө албан ёсоор бүртгүүлэх, шаардлага хангаж буй эсэхийг шалгуулахаар Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д ирүүлнэ.

4.2.4.3. Дэд төслийн хүрээнд санхүүжүүлэх боломжгүй үйл ажиллагаанууд

Дэд төслийн санхүүжилтээс дэмжлэг үзүүлэх боломжгүй дараах үйл ажиллагаанууд орно. Үүнд:

- Дэлхийн банкны хамгааллын бодлоготой нийцээгүй үйл ажиллагаа: Төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (ESMF)-д тодорхойлсон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлого, шаардлагыг хангаагүй аливаа үйл ажиллагаа;
- Тэтгэлгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд бөгөөд онцгой хамааралгүй хоршоо, малчдын удирдлага, захиргааны болон давхардсан зардлууд;
- Тэтгэлгийн гэрээнд оролцоогүй, эсхүл тэргүүлэх хоршоотой албан ёсоор холбоогүй гуравдагч этгээдээр дамжуулан үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- Газрын худалдан авалт, тээврийн хэрэгсэл худалдан авах, үйлдвэр байгуулах зэрэг хөрөнгө оруулалтууд;
- Сургалтын тэтгэлэг, сургалтын төлбөр зэрэг ерөнхий боловсролын үйл ажиллагаа. Харин зорилтот бүс нутагт олон нийтийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, туршлага түгээх зорилгоор сургуулийг олон нийтийн төв болгон ашиглах тохиолдлыг үүнд хамааруулахгүй.

4.2.5. ДЭД ТӨСЛИЙН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ

Хоршоо Дэд төслийн саналаа эцэслэн боловсруулж хүргүүлсний дараа ТХН нь бичиг баримтын бүрдлийг шалгаж, хүлээн авна. Дараах алхамын дагуу гүйцэтгэнэ:

Хоршоод дэд төслийн саналын боловсруулж ирүүлсний дараа Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь ирүүлсэн баримт бичгүүдийг албан ёсоор хүлээн авч, шалгана. Үүний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Ирүүлсэн өргөдөл бүрт давтагдашгүй код олгох;
- Шаардлагатай бүх баримт бичиг бүрэн, зохих ёсоор гарын үсэг зурж, тамгалсан эсэхийг шалгах;
- Хоршоо улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн эсэхийг нягтлах;
- Хамтран санхүүжилтийн баталгааг шалгаж, эрх зүйн болон шалгуурын нийцлийг нягтлах;

- Байгаль орчны анхан шатны үнэлгээ, хамгааллын ангилал.

Дутуу бүрдүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй дэд төслийн саналыг боломжит хугацааны хүрээнд засвар, сайжруулалт хийх санал, тайлбарын хамт өргөдөл гаргагчид буцаана. Харин албан ёсоор хүлээн авсан төслийн саналуудыг Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн (SGP) эцсийн шатны сонгон шалгаруулалтад үнэлүүлэхээр Техникийн үнэлгээний хороонд шилжүүлнэ.

4.2.6. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА БОЛОН ЭЦСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ

Олон нийтэд зарласан эцсийн хугацаа дууссаны дараа нэмэлт төслийн санал хүлээн авах, эсхүл өмнө ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй.

Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) нь албан ёсоор хүлээн авсан бүх дэд төслийн саналуудыг дараах шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурласан нарийвчилсан үнэлгээний матрицаар үнэлнэ. Үүнд:

- Төслийн техникийн хэрэгжих боломж болон эдийн засгийн үр ашиг;
- Хоршооны чадавх болон засаглалын бэлэн байдал;
- Хүртээмж, оролцоо (хүйс, залуучууд, эмзэг өрхүүдийн оролцоо);
- Хэрэгжилт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний бодит байдал, хэрэгжих боломж;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний удирдлага;
- Ажлын байр бий болгох, орлогыг нэмэгдүүлэх, зах зээлд борлуулах боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавх.

Үнэлгээний оноонд үндэслэн Техникийн үнэлгээний хороо (ТҮХ) нь эцсийн жагсаалтыг дараах байдлаар ангилан боловсруулна. Үүнд:

- Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрт (ЭСЖТХ) шууд хамруулах боломжтой дэд төслийн саналууд;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн боломжит байдлаас хамааран ЭСЖТХ-т хамруулж болох дэд төслийн саналуудын жагсаалт;
- Шалгарч чадаагүй дэд төслийн саналууд, үндэслэл, тайлбарын хамт.

Боловсруулсан эцсийн жагсаалтыг Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) албан ёсоор баталж, Дэлхийн банкны ил тод байдлын шаардлагад нийцүүлэн олон нийтэд нээлттэйгээр мэдээлнэ.

4.2.7. ЭСЖТХ-ИЙН ЭЦСИЙН ШИЙДВЭР ГАРГАЖ БАТЛАХ

Энэ үе шат нь хоршоодыг албан ёсоор сонгон шалгаруулахад чиглэсэн бөгөөд өрсөлдөөнт, ил тод, техникийн нарийвчилсан үнэлгээний үйл явцаар дамжуулан өндөр чанартай, үр ашигтай дэд төслүүдийг тодорхойлох зорилготой.

4.2.7.1. *Үнэлгээ хийх үйл явц*

Төслийн Зөвлөх Хороо (эсвэл Төслийн Удирдах Хороо) дараах үндсэн чиглэлүүдийн хүрээнд үнэлгээ хийнэ. Үүнд:

- Техникийн үндэслэл: Үйлдвэрлэлийн загвар, ашиглах технологи болон хүрэх зорилтот үр дүн;
- Бизнесийн үр ашиг: Санхүүгийн загвар, хамтран санхүүжилт болон бодит мөнгөн урсгал;
- Нийгмийн нөлөө: Ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, залуучууд болон эмзэг бүлгийн оролцоо;
- Хоршооны чадавх: Дотоод засаглал болон удирдлагын бэлэн байдал;
- Хамгааллын шаардлагын нийцэл: Эрсдэлийн үнэлгээ болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
- Газарзүй, салбарын тэнцвэрт байдал: Хөрөнгө оруулалтын бүс нутаг болон төрөл, чиглэл.

4.2.7.2. *Батлах үйл явц*

Төслийн Удирдах Хороо (эсвэл Төслийн Зөвлөх Бүлэг) нь дараах үндсэн шийдвэрүүдийг батална. Үүнд:

- Дэд төслийн санхүүжилтийн боломжит дээд хэмжээ;
- Оролцооны олон талт байдал, тэгш хүртээмжийг хангахтай холбоотой асуудлууд.

Гаргасан шийдвэрийг Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д танилцуулж, батлуулахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (MOFALI)-нд хүргүүлнэ.

4.2.7.3. *Мэдээлэх, санал хүсэлт хүлээн авах*

Үнэлгээний үр дүнг албан ёсны мэдэгдлийн бичгээр хүргэхийн зэрэгцээ Хөтөлбөрийн цахим хуудас болон мэдээллийн самбаруудаар дамжуулан олон нийтэд нээлттэйгээр мэдээлнэ. Хоршоо бүр дараах мэдээллийг хүлээн авна. Үүнд:

- Үр дүнгийн талаарх мэдэгдэл (шалгарсан, нөөцөд багтсан, эсхүл шалгараагүй);
- Үнэлгээний товч дүгнэлтийн хуулбар (хүсэлт гаргасан тохиолдолд);
- Давж заалдах хүсэлт гаргах, эсхүл санал, тайлбар авах боломж.

4.2.8. ДЭД ТӨСЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Шалгарсан хоршоод тодорхойлогдсоны дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (MOFALI) нь шалгарсан хоршоод бүртэй дэд төслийн гэрээ байгуулах үйл явцыг эхлүүлнэ. Энэхүү гэрээ нь дэд төслийг хэрэгжүүлэх, тайлагнах болон хөтөлбөрийн нөхцөл, шаардлагыг мөрдөхтэй холбоотой эрх зүйн харилцааг албан ёсоор баталгаажуулна.

4.2.8.1. Гэрээний бүтэц

Гэрээ бүр нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (MOFALI) (Төсөл хэрэгжүүлэх нэгж – ТХН-ээр дамжуулан төлөөлүүлсэн) болон хоршооны хооронд байгуулагдах хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичиг байна. Гэрээнд дараах үндсэн заалтуудыг тусгана. Үүнд:

- Олгох санхүүжилтийн нийт дүн болон батлагдсан төсвийн ангиллууд;
- Хоршооны хамтран санхүүжилтийн үүрэг, хариуцлага;
- Үе шатны зорилт, шалгуурын биелэлттэй уялдсан санхүүжилт олгох хуваарь;
- Хоршоо, Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН), Хамтран хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлага;
- Худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага болон хамгааллын шаардлагыг мөрдөх үүрэг;
- Хяналт-шинжилгээ, тайлагнал болон баталгаажуулалтын журам;
- Хөрөнгийг ашиглах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой нөхцөл, заалтууд;
- Маргаан шийдвэрлэх, гэрээ цуцлах болон шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг буцаан олгох нөхцөлүүд.

Гэрээ бүр нь тухайн хоршооны дэд төслийн санал болон үнэлгээний үр дүнд нийцүүлэн боловсруулагдах боловч ХХААХҮЯ-аас баталсан стандарт загварын дагуу, мөн Япон улсын нийгмийн хөгжлийн сан болон Дэлхийн банкны дүрэм, журмуудтай уялдсан байна.

4.2.8.2. Гэрээ байгуулахаас өмнөх баталгаажуулалт

Гэрээнд гарын үсэг зурахаас өмнө Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь дараах нөхцөлүүд хангагдсан эсэхийг нягтална. Үүнд:

- Хоршоо хууль ёсоор улсын бүртгэлд бүртгэгдэж, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;
- Хамтран санхүүжилтийн хөрөнгийг дансанд байршуулсан, эсхүл албан ёсоор баталгаажуулсан эсэх;
- Хоршооны банкны данс нээгдэж, ашиглах боломжтой эсэх;
- Сургалтад хамрагдсан, бэлтгэгдсэн удирдлагын баг бүрдсэн эсэх;
- Байгаль орчин, нийгмийн хамгаалалтай холбоотой нэмэлт шаардлагууд (шаардлагатай тохиолдолд) бүрэн хангагдсан эсэх.

Тухайн хоршоонд хариуцан ажиллах Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн ажилтан эдгээр нөхцөлүүдийг баталгаажуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгахад шаардлагатай дэмжлэг, зөвлөгөөг үзүүлнэ.

4.2.8.3. Санхүүжилт болон үе шатаар санхүүжүүлэх хуваарь

Дэд төслийн хүрээнд олгох санхүүжилтийг хоршоодод хэд хэдэн үе шаттайгаар шилжүүлэх бөгөөд энэ нь тодорхой шалгуур, үе шатны биелэлтийг баталгаажуулсны үндсэн дээр хийгдэнэ (жишээлбэл: тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулагдсан байх, бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн гэрээ, үйл ажиллагаа эхэлснийг нотлох баримт бичиг бүрдсэн байх гэх мэт).

Санхүүжилт олгох хуваарь буюу “Санхүүжилт шилжүүлэх хуваарь болон төлбөр олгохоор санал болгож буй үе шатны шалгуур” нь тэтгэлгийн төслийн саналын салшгүй хэсэг бөгөөд уг гэрээнд хавсралтаар орж, дараах мэдээллийг тодорхой тусгана. Үүнд:

- Санхүүжилт олгох хүлээгдэж буй хугацаа;
- Баталгаажуулалтад шаардагдах баримт бичгүүд (хүргэлтийн баримт, нэхэмжлэх, гэрэл зураг зэрэг);
- Хоршооны хүлээх үүрэг, хариуцлага болон тайлагналын шаардлагууд.

4.2.8.4. Гэрээ

Гэрээг дараах байдлаар гурван хувь үйлдэнэ. Үүнд:

- Нэг хувь нь хоршоонд;
- Нэг хувь нь Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д;
- Нэг хувь нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (MOFALI)-ны албан ёсны архивт хадгалагдана.

Гэрээнд гарын үсэг зурснаар Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөр нь албан ёсоор хэрэгжилтийн үе шатанд шилжинэ.

4.2.9. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагаа нь Санхүүжилтийн гэрээний 1.02 (к) болон 2.03 (с) (ii) (В) (2) (с)-д заасны дагуу Дэлхийн банкнаас баталсан Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдийн худалдан авалтын журам (Procurement Regulations for IPF Borrowers, PRs)-ыг мөрдөнө.

Тэтгэлгийн гэрээнд гарын үсэг зурсны дараа хоршоод нь батлагдсан дэд төслийн хүрээнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг Хавсралт 3-т тодорхойлсон журмын дагуу хэрэгжүүлж эхэлнэ.

4.2.9.1. Хоршоодоор худалдан авах ажиллагаа явуулах

Бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хоршоод өөрсдөө зохион байгуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим платформыг ашиглана. Санхүүжилтийг хоршооны борлуулалт, худалдан авалтын гэрээ болон үнийн саналуудын үндсэн дээр олгоно. Худалдан авах ажиллагааг энэхүү гарын авлагад заасан журам, босго хэмжээг чанд мөрдөн хэрэгжүүлэх бөгөөд үүнд дараах хэлбэрүүд хамаарна. Үүнд:

- Өрсөлдөөнт үнийн санал авах: Гарын авлагад тодорхойлох босго хэмжээнээс дээш дүнтэй гэрээний хувьд Үнийн санал авах хүсэлт (RFQ)-ийн дагуу, үндэсний стандарт тендерийн баримт бичгийг ашиглан, Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журмын (PRs) 5.3, 5.4, 5.5 болон 6.7-д заасны дагуу дор хаяж гурван өрсөлдөөнт үнийн санал цуглуулна;
- Хялбаршуулсан шүүд худалдан авалт: Маш бага үнийн дүнтэй (1,000 ам.доллараас доош) гэрээний хувьд хялбаршуулсан журмыг хэрэглэж болно;
- Бүртгэлтэй нийлүүлэгч ашиглах: Худалдан авалтыг тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх эрх бүхий, албан ёсоор зөвшөөрөгдсөн аж ахуйн нэгжээс хийх шаардлагатай;
- Ил тод байдал, баримтжуулалт: Худалдан авах ажиллагааны бүх үе шатыг (RFQ, үнийн саналын үнэлгээ, сонголтын үндэслэл, байгуулсан гэрээ гэх мэт) цахим платформд бүрэн баримтжуулна.

Худалдан авах ажиллагааны талаархи мэдээллийг заавал Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д тайлагнана.

4.2.9.2. Нэмэлт дэмжлэг

Цахим платформоор дамжуулан Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь хоршоодод дараах чиглэлээр дэмжлэг үзүүлж болно. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны дүрэм, журмын талаар сургалт зохион байгуулах;
- Тендерийн баримт бичиг боловсруулах, үнийн санал авах хүсэлт (RFQ) бэлтгэхэд туслалт;
- Нийлүүлэгчийн чадавх, санал болгож буй гэрээнүүдийг хянан үзэх;
- Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, чанарыг шалгаж баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;
- Санхүүжилтийн дараагийн шатны шилжүүлгийг хийхэд шаардлагатай худалдан авах ажиллагааны баримт бичгийг ТХН-д ирүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь ердийн нөхцөлд хоршоодын өмнөөс худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхгүй. Харин онцгой тохиолдолд (жишээлбэл: хоршооны чадавх

хүрэлцэхгүй байх, давагдашгүй хүчин зүйл үүсэх, эсхүл хоршооны хүсэлтээр урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд) уг үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

4.2.9.3. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс худалдан авах ажиллагаанд хяналт тавих

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь худалдан авах ажиллагаанд дараах хэлбэрээр хяналт тавина. Үүнд:

- Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг санамсаргүй түүвэрлэн шалгаж, журам, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан баталгаажуулах;
- Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь батлагдсан төсөвт тусгагдсан техникийн тодорхойлолт, тоо хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг нягтлах;
- Зөрчил, хууль бүс үйлдэл, залилангийн шинжтэй эрсдэлийг илрүүлсэн тохиолдолд тэмдэглэн, залруулах арга хэмжээг шуурхай авах.

4.2.10. ДЭД ТӨСЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭСХҮЛ ЦУЦЛАХ

Дэд төслийн санхүүжилтийг батлагдсан зорилгоос өөр зориулалтаар ашиглаж болзошгүй гэсэн сэжиг илэрсэн, эсхүл дараах аливаа шалтгааны улмаас дэд төслийн гэрээг цуцлах шаардлага үүссэн тохиолдолд Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь урьдчилсан шалгалт хийж, Төслийн Удирдах Хороо (PSC) эсхүл Төслийн Зөвлөх Бүлэг (PAG)-ийн зөвшөөрлийг авч, дэд төслийн гэрээг цуцлах тухай албан ёсны мэдэгдлийг хүргүүлнэ.

4.2.10.1. Гэрээг цуцлах үндэслэлүүд

Дэд төслийн гэрээг цуцлах үндэслэлд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:

- Дэд төслийн гэрээнд заасан үүрэг, хариуцлагыг биелүүлээгүй;
- Батлагдсан дэд төслийн саналд тусгагдаагүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн;
- Хөрөнгө, эд хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, эсхүл завшсан;
- Дэд төслийг хэрэгжүүлэх хугацаанд үйл ажиллагааг зогсоосон, эсхүл байгууллагын бүтэц, удирдлагад өөрчлөлт орсны улмаас хэрэгжилтийн чадавх мэдэгдэхүйц буурсан;
- Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн хяналт-шинжилгээ, хянан шалгалт, үнэлгээгээр дэд төслийн хүлээгдэж буй үр дүнд ноцтой эрсдэл учруулж болзошгүй гэж тогтоогдсон бусад нөхцөл байдал.

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь гэрээг цуцлах үндэслэлийг тайлбарласан бичгээр мэдэгдлийг хоршоонд хүргүүлнэ. Хэрэв хоршооноос хариу ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлбар, үндэслэлийг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд ТХН нь дэд төслийн гэрээг цуцлах тухай шийдвэрийн төслийг боловсруулж, Төслийн Удирдах Хороо (PSC) эсхүл Төслийн Зөвлөх Бүлэг (PAG)-т танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.2.10.2. *Гэрээ цуцлагдсан тохиолдлын үр дагавар*

Дэд төслийн гэрээ цуцлагдсан тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь тэтгэлгийн хүрээнд санхүүжүүлсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлнэ;
- Шилжүүлсэн тоног төхөөрөмжийг ТХН нь нөөц жагсаалтад багтсан, ижил төстэй дэд төсөл хэрэгжүүлж буй өөр хоршоонд дахин хуваарилах боломжтой;
- Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь Төслийн Удирдах Хороо (PSC) эсхүл Төслийн Зөвлөх Бүлэг (PAG)-т дараах мэдээллийг багтаасан тайланг хүргүүлнэ. Үүнд:
 - Дэд төслийн гэрээг цуцлахтай холбоотой албан ёсны бичиг баримтууд;
 - Шилжүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт;
 - Хөрөнгийн ашиглалтын тайлан;
 - Ашиглагдаагүй хөрөнгийг нөхөн сэргээх, дахин ашиглахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний явц.

4.2.11. **ЭРЭЛТЭД СУУРИЛСАН ЖИЖИГ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН (ЭСЖТХ) ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХААЛТ**

Төслийн үйл ажиллагааны гарын зааврын IX бүлэгт заасны дагуу хөтөлбөр нь хэрэгжилтийн хугацаанд зорилтуудаа бүрэн хангаж биелүүлэхийг зорих бөгөөд төсөл хаагдсаны дараа сайн туршлагыг бий болгож, түүнийг тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Орон нутгийн малчдын хоршоодыг тогтвортой үйлдвэрлэлийн арга барилд шилжих, түүнийг нэвтрүүлэх чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс төслийн эхнээс дуусах хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх тогтвортой байдал болон хаалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.2.11.1. *Дэд төслийн хаалтын төлөвлөгөө*

Дэд төслүүд нь шат дараатайгаар хоршоодод хөрөнгийн өмчлөх эрхийг өгөх, орон нутгийн засаг захиргаа болон бусад оролцогч талуудаас өмчлөл, хариуцлагыг шатлалтайгаар шилжүүлснээр хөтөлбөрийн үйл ажиллагааг хаана. Цаашид хоршоод тогтвортой ажиллах, сайн туршлагыг өргөжүүлэн түгээх, тогтмол ашиглалт арчилгаа үйлчилгээг хариуцна.

Тогтвортой байдлыг хангах үүднээс дараах үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг дэд төслийн гэрээнд тусгана. Үүнд:

- Төслийн хүрээнд дэмжигдсэн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчдын оролцоо нэмэгдсэн байх;
- Амжилттай туршлагыг давтан хэрэгжүүлэх (хэмжээг тэлэх, түгээн дэлгэрүүлэх) үйл ажиллагааг дэмжих;

- Олж авсан мэдлэг, ур чадварыг бодит үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, тухайн орон нутагт ноос, ноолуурын үйлдвэрлэлийн сайжруулсан арга, технологийг сурталчлан түгээх.

4.2.11.2. Эд хөрөнгийн өмчлөл, шилжүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Есдүгээр бүлгийн 76, 80 болон 81 дүгээр зүйлийн хүрээнд мөн дэд төслийн гэрээнд зааснаар хоршоод ЭСЖТХ-өөр санхүүжүүлсэн бараа, ажил, үйлчилгээгээр бий болсон хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өмчлөх эрх үүснэ.

Гэрээний хүрээнд худалдан авсан хөрөнгө нь дэд төслийн хэрэгжилтийн хугацаанд хоршооны эзэмшилд байх бөгөөд дэд төслийн гэрээнд заасан хугацаа дууссаны дараа дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд тухайн хөрөнгийг хоршооны өмчлөлд албан ёсоор шилжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан байх;
- Гэрээний нөхцөл, шаардлагуудыг бүрэн хангаж биелүүлсэн байх;
- Хяналт-шинжилгээний тайлангууд хангалттай, эерэг дүгнэлттэй байх.

Хүснэгт 3. Эрэлтэд суурилсан жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг (ЭСЖТХ) хэрэгжүүлэх үйл явц

